

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 14 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 14 дүгээр хуралдааныг 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 14 цаг 20 минутад Засаг даргын Тамгын газрын II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 83.3 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам нарт хүндэтгэл үзүүлэх асуудлыг хэлэлцүүлэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангайд хүндэтгэл үзүүлэхэд Хөшөөт хөгжил сангийн ирэх оны төсөвт 3 өрөө байрны санхүүжилтийг төсөвлөн батлуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал Т.Мягмардорж нарт үүрэг болгов.</p> <p>2. Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам нарт хүндэтгэл үзүүлэх, баяр наадам зохион байгуулахад төрийн албан хаагчдыг татан оролцуулж, хандив цуглуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод;</p> <p>3. Дээрх арга хэмжээнд хандив цуглуулах ажилд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Прокурорын газар, Тагнуулын газар, Шүүхийн Тамгын газрыг тус тус хариуцан зохион байгуулахыг аймгийн Засаг дарга Б.Дүгэржавт;</p> <p>4. Дээрх арга хэмжээнд аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус болон иргэний нийгмийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн газруудыг татан оролцуулж, хандив цуглуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбасүрэнд;</p> <p>5. Дээрх арга хэмжээнд аймагт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, хандив цуглуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүх нарт тус тус үүрэг болгов.</p> <p>6. Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам нарт хүндэтгэл үзүүлэх, баяр наадам зохион байгуулахад зарцуулагдах хандив цуглуулах ажлыг орон нутагт үр</p>

		<p>дүнтэй зохион байгуулахыг 17 сумын Засаг дарга нар болон дараах нэр бүхий албан тушаалтнуудад үүрэг болгов.</p> <p>Үүнд:</p> <p>6.1. Алтай сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Түмэндэмбэрэлд;</p> <p>6.2. Булган сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Л.Билэгдэмбэрэл, Соёл, урлагийн газрын дарга М.Пүрэвхүү нарт;</p> <p>6.3. Буянт сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч П.Эрдэнэ-Очирт;</p> <p>6.4. Дарви сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярсүхэд;</p> <p>6.5. Дөргөн сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Т.Заяад;</p> <p>6.6. Дуут сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг “Шим-Ус” ОНӨААТҮГ-ын дэд дарга н.Энхбаярт;</p> <p>6.7. Манхан сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Пүрэвгандид;</p> <p>6.8. Мөст сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Цэргийн штабын дарга Б.Ганхуяг, Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Б.Гомбосүрэн нарт;</p> <p>6.9. Мөнххайрхан сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Х.Болдбаатарт;</p> <p>6.10. Мянгад сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадоржид;</p> <p>6.11. Зэрэг сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг аймгийн Засаг даргын орлогч Т.Дэлгэрсайханд;</p> <p>6.12. Жаргалант сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Отгонцагаан, Засаг даргын орлогч Б.Туулайтулга нарт;</p> <p>6.13. Цэцэг сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Б.Батнасан;</p> <p>6.14. Үенч сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Батнасан;</p> <p>6.15. Ховд сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал;</p> <p>6.16. Чандмань сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг “Ховд АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Батцагаанд;</p> <p>6.17. Эрдэнэбүрэн сумын иргэдээс хандив цуглуулах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын</p>
--	--	---

		нарийн бичгийн дарга Б.Сандагсүрэнд; 7. Тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг чиглэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн 2022 оны 09 дүгээр сарын 12-ны дотор Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч Т.Дэлгэрсайханд үүрэг болгов.
2	"Хан жаргалантын хурд-2022" Баруун бүсийн даншиг наадмын тайлан хэлэлцүүлэх тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. "Хан жаргалантын хурд-2022" Баруун бүсийн даншиг наадам зохион байгуулах үйл ажиллагааны зардлын дутуу 9.760,000 төгрөг (есөн сая долоон зуун жаран мянга)-ийн санхүүжилтийн эх үүсвэр гаргах боломжийг судлан шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Чандмань сумын Засаг дарга З.Онолбаатар нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР